



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/ААС

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1. дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Автомат галын хорыг мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	М.Даваажав	Нисэхийн сургалтын төвийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа- галын аюулгүй байдал, хяналтын инженер
Нарийн бичгийн дарга:	Б.Санчир	Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн
Гишүүд:	Ч.Чимэддорж	"Чингис хаан" Олон улсын нисэх буудлын Аврах, гал унтраах албаны аврах ажиллагааны мэргэжилтэн
	Ц.Уянга	Нисэх буудлуудын удирдах газрын Нисэх буудлуудын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Г.Одбаяр	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /М.Даваажав/-нд даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, Тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Б.Санчир/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН